



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Асгат сумын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/62/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Заяа Утас:92038288 Цахим хаяг: zayag@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/220
танай _____ -ны № _____ -т

АСГАТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.ӨЛЗИЙЖАРГАЛ -д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

5.2 сая төгрөгийн зардлын Э баримтыг бүрэн бүрдүүлээгүй, 4.5 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа, өмнөх оны актын төлбөрийг ажилтнуудаас суутгаагүй, 3.8 сая төгрөгийн хэмнэгдсэн зардлыг зориулалт бус зарцуулан, худалдан авсан бараа материалыг бүртгэлд тусгаагүй, 1.1 сая төгрөгийн зарцуулалт анхан шатны баримтаар нотлогдоогүй зэрэг зөрчлүүд нь (Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5,13.6, 20.2.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.4 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт зэрэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй) байна.

01302/165

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,176,044.61	17,417,682.01
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
3121	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	27,176,044.61	17,417,682.01
351	Түүхий эд материал	2,454,199.40	2,804,788.40
35110	Тусгай зориулалттай материал	2,313,239.40	2,804,788.40
3510	Эм боох материал	140,960.00	
35400	Хангамжийн материал	24,721,845.21	14,612,893.61
35410	Бичиг хэргийн материал	3,329,570.00	1,047,297.00
35420	Аж ахуйн материал	9,506,622.00	5,216,362.00
35440	Түлш, шатах тослох материал	20,000.60	
35450	Хүнсний материал	11,865,652.61	8,349,234.61
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	101,094,009.96	119,775,794.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	101,094,009.96	119,775,794.88
39200	Биет хөрөнгө	95,044,009.96	114,055,794.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	89,778,900.00	89,778,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,299,180.04	-4,795,495.08
39205	Машин тоног төхөөрөмж	14,951,752.00	33,659,652.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,452,752.00	-12,152,552.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,105,890.00	9,605,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,105,890.00	-7,105,890.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,544,000.00	4,544,000.00
39217	Ном фонд	521,290.00	521,290.00
39300	Биет бус хөрөнгө	6,050,000.00	5,720,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00

39302	Хасагдуулга		-330,000.00
39303+393	Бусад биет бус хөрөнгө	4,400,000.00	4,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	128,270,054.57	137,193,476.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	128,270,054.57	137,193,476.89
51	Засгийн газрын хувь оролцоо	128,270,054.57	137,193,476.89
51100	Засгийн газрын оруулсан капитал	48,148,231.80	48,148,231.80
51101	Өмч: -Төрийн өмч	48,148,231.80	48,148,231.80
51200	Хуримтлагдсан үр дүн	-490,651.23	8,432,771.89
51210	Өмнөх үеийн үр дүн	-490,651.23	-490,651.23
51220	Тайлант үеийн үр дүн		8,923,422.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,612,474.00	80,612,474.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	128,270,054.57	137,193,476.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	709,728,800.00	773,269,991.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,799,800.00	1,596,581.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,596,581.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,596,581.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,596,581.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	704,929,000.00	771,673,410.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	120,691,000.00	142,592,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	120,691,000.00	142,592,500.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	00.00	23,977,210.73
1330	Төсвийн захирагчдаас	582,554,200.00	629,080,910.73
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	582,554,200.00	605,103,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	714,262,667.66	779,215,316.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	714,262,667.66	779,215,316.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,902,964.66	738,329,674.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	461,511,373.00	483,722,770.00
210101	Үндсэн цалин	461,511,373.00	483,722,770.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,348,076.77	66,788,379.22
210201	Тэтгэврийн даатгал	39,381,453.77	46,622,413.22

Асгат сумын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	11,770,235.00	4,855,267.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,231,907.00	3,884,213.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,496,772.00	884,756.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,467,709.00	10,541,730.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,222,266.00	124,802,594.01
210301	Гэрэл, цахилгаан	1,163,260.00	2,571,258.00
210302	Түлш, халаалт	114,054,506.00	121,135,536.00
210303	Цэвэр, бохир ус	1,004,500.00	1,095,800.01
2104	Хангамж, бараа материалын зардал	14,171,152.00	11,373,795.00
210401	Бичиг хэрэг	2,104,900.00	2,989,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,637,540.00	3,480,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,480,300.00	1,337,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,888,412.00	3,566,305.00
2105	Нормативт зардал	10,748,595.00	28,597,266.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,614,500.00	1,027,500.00
210502	Хоол, хүнс	7,255,995.00	27,282,806.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,878,100.00	286,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	3,500,000.00
210604	Урсгал засвар	00.00	3,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,050,000.00	2,304,000.00
210702	Дотоод албан томилолт	1,050,000.00	2,304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,105,834.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,745,667.89	16,440,869.84
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,660,712.00	1,218,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,084,955.89	15,222,669.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,359,703.00	40,885,641.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,588,440.00	34,716,718.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,439,940.00	11,315,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	22,901,518.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,148,500.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,168,923.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,168,923.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-4,533,867.66</u>	<u>-5,945,324.57</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-4,533,867.66</u>	<u>-5,945,324.57</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-	285,271,518.27	511,123,082.08	-135,528,867.07	00.00	660,865,733.28

	нээрх үлдэгдэл					
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	285,271,518.27	00.00	- 135,528,867.07	00.00	149,742,651.20
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,533,867.66	00.00	-4,533,867.66
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	285,271,518.27	00.00	- 140,062,734.73	00.00	145,208,783.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	285,271,518.27	00.00	- 140,062,734.73	00.00	145,208,783.54
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,945,324.57	00.00	-5,945,324.57
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	285,271,518.27	00.00	- 146,008,059.30	00.00	139,263,458.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	704,929,000.00	771,673,410.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	704,929,000.00	771,673,410.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	120,691,000.00	166,569,710.73
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	120,691,000.00	142,592,500.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	00.00	23,977,210.73
1330	Төсвийн захирагчдаас	582,554,200.00	605,103,700.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	582,554,200.00	605,103,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	697,879,100.00	771,673,410.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	697,879,100.00	771,673,410.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	674,519,397.00	730,787,769.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	461,511,373.00	483,722,770.00
210101	Үндсэн цалин	343,535,889.00	327,831,418.00
210102	Нэмэгдэл	93,095,387.00	133,487,765.00

Асгат сумын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	24,880,097.00	22,403,587.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,845,357.00	66,291,098.99
210201	Тэтгэврийн даатгал	44,472,300.00	46,875,799.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,015,200.00	4,860,499.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,212,200.00	3,861,499.54
210204	Ажилгүйдлийн даатгал	5,115,457.00	972,099.70
210205	Эрүүл мэндийн даатгал	8,030,200.00	9,721,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,828,360.00	139,119,500.01
210301	Гэрэл, цахилгаан	1,163,260.00	5,961,600.00
210302	Түлш, халаалт	112,660,600.00	132,062,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,004,500.00	1,095,800.01
2104	Хангамж, бараа материалын зардал	15,880,712.00	8,132,400.00
210401	Бичиг хэрэг	2,357,300.00	746,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,575,800.00	2,368,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,480,300.00	1,337,000.00
210404	Ном, хэвлэл	375,000.00	857,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,062,312.00	2,823,000.00
2105	Нормативт зардал	12,273,295.00	24,641,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,642,000.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	9,361,295.00	22,871,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,270,000.00	770,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	3,500,000.00
210604	Урсгал засвар	00.00	3,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,050,000.00	2,304,000.00
210702	Дотоод албан томилолт	1,050,000.00	2,304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,191,700.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,938,600.00	2,276,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,938,600.00	2,276,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,359,703.00	40,885,641.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,588,440.00	34,716,718.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,439,940.00	11,315,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	22,901,518.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,148,500.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	6,168,923.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,168,923.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	750,263,300.00	742,602,969.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	750,263,300.00	742,602,969.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	738,448,100.00	730,787,769.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	490,481,600.00	483,722,770.00
210101	Үндсэн цалин	329,462,200.00	327,831,418.00
210102	Нэмэгдэл	135,746,200.00	133,487,765.00
210104	Урамшуулал	25,273,200.00	22,403,587.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,215,000.00	66,291,098.99
210201	Тэтгэврийн даатгал	46,595,800.00	46,875,799.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,904,800.00	4,860,499.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,923,900.00	3,861,499.54
210204	Ажилгүйдлийн даатгал	980,900.00	972,099.70
210205	Эрүүл мэндийн даатгал	9,809,600.00	9,721,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,092,500.00	139,119,500.01
210301	Гэрэл, цахилгаан	5,961,600.00	5,961,600.00
210302	Түлш, халаалт	141,062,100.00	132,062,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,068,800.00	1,095,800.01
2104	Хангамж, бараа материалын зардал	8,312,100.00	8,132,400.00
210401	Бичиг хэрэг	755,300.00	746,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,200,800.00	2,368,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	1,337,000.00
210404	Ном, хэвлэл	1,133,000.00	857,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	423,000.00	2,823,000.00
2105	Нормативт зардал	19,770,400.00	24,641,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	18,000,000.00	22,871,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,400.00	770,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	3,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	3,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,057,400.00	2,304,000.00
210702	Дотоод албан томилолт	1,057,400.00	2,304,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2719100.00	2276600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,719,100.00	2,276,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11815200.00	11815200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,815,200.00	11,815,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,315,200.00	11,315,200.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	750,263,300.00	747,696,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	149,092,500.00	142,592,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	149,092,500.00	142,592,500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	43.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		22,901,518.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		22,901,518.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	22901518.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		22,901,518.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		22,901,518.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Асгат сумын 9 жилийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Г.Заяа, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Асгат сумын 9 жилийн сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Асгат сумын 9 жилийн сургууль нь хүүхдийн бие даан хөгжих, бүтээлчээр, суралцахад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж, ахлах ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргахад дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Асгат сумын 9 жилийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 767.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	497.3	3,759.4	3,262.1
Бараа материал	19,073.0	15,359.5,461.90	-3,713.5
Үндсэн хөрөнгө	644,953.7	631,327.7	-13,626.0
Нийт хөрөнгө	664,524.0	650,446,5	-14,077.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	664,524.0	650,446,5	-14,077.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	664,524.0	650,446,5	-14,077.5

Авлага дансны үлдэгдэл 3,262.1 мянган төгрөгөөр өссөн нь аудитын залруулгатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,713.5 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,626.0 мянган төгрөгөөр буурсан нь мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,077.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 601,170.8 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 149,092.5 мянган төгрөгийн, нийт 750,263.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 750,263.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 605,103.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 143,668.2 мянган төгрөгийн, нийт 748,771.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 742,603.0 мянган төгрөгийг зарцуулан, 6,168.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд орон нутгийн төсвөөс 22,901.5 мянган төгрөгийн санхүүжилт авч тэтгэмжид зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл хөтлөлтөд тавих тавих дотоод хяналт хангалтгүй, хэмнэгдсэн зардлыг зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг зөрчсөн, хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн зэрэг зөрчлүүдийг онцлон авч үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Ажилтнуудад цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, цалингийн урьдчилгаа, актын төлбөрийг суутгаагүй, зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулаагүй, худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй, эд хариуцагчтай тооцоо бодож хэвшээгүй, хэмнэгдсэн зардлыг зарцуулахдаа холбогдох журмыг зөрчсөн, хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлсэн зэрэг зөрчлүүд илэрлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг программаар шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 22 мэдээллээс 16 мэдээллийг байршуулан, доорх 6 мэдээллийг байршуулаагүй байна.

- ✓ 1,2,3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- ✓ 2020 оны санхүүгийн тайлан
- ✓ 2020 оны аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- ✓ 309,948.3 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
- ✓ 138,231.0 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ
- ✓ 3,759.4 мянган төгрөгийн авлагын мэдээлэл, үүсгэсэн шийдвэр

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодогчид зардлыг бүртгэхдээ бараа материалын болон өглөгийн дансаар дамжуулах, эд хариуцагчтай тооцоо бодож хэвших, эд хөрөнгийн тооллогод хяналт тавих, эд хариуцагчид бараа материалын тайланг сар бүр бүрэн гаргаж байх хугацаатай үүргүүдийг өгч биелэлтийг тооцох, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 614,496.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 146,269.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,475.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 457,751.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа:

Санхүүгийн байдлын тайланд 7,149.7 мянган төгрөгийн, өглөгийн тодруулгад 139,119.5 мянган төгрөгийн, нийт 146,269.2 мянган залруулга хийгдсэн. Төлбөрийн актаас 2,628.4 мянган төгрөгийг аудитын хугацаанд барагдуулсан.

4.2 Төлбөрийн акт :

1.1. Илрүүлэлт:

- ✓ Нэр бүхий ажилтнуудаас 7,078.9 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа, өмнөх аудитын актын төлбөр зэргийг суутгаагүй, ажилтанд цалингийн нэмээдлийг илүү тооцоолж олгосон;
- ✓ 3,397.0 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтын баримтыг хуурамчаар бүрдүүлэн, сургуулийн мөнгөн хөрөнгийг дутагдуулсан;

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3, 4.2.3.7 дахь заалтуудыг үндэслэн илүү тооцож олгосон цалин хөлс, дутагдуулсан мөнгөн хөрөнгийг нөхөн төлүүлэхээр 10,475.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

- ✓ Гэрэл цахилгааны зардлын хэмнэлтээс 3,752.0 мянган төгрөгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг зөрчсөн, 361.7 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг үнэн зөв тайлагнаагүй;
- ✓ 5,451.0 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй;

- ✓ Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд шилэн дансны цахим мэдээллийн санд 451,938.7 мянган төгрөгийн 6 төрлийн мэдээллийг мэдээлээгүй зөрчлийг давтан гаргасан.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 оны тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6, 4.2.1.10 дахь заалтуудыг үндэслэн 133,480.3 мянган зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх үүргийг албан шаардлагаар хүргүүлээ.

4.4 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Асгат сумын сургууль	5	614,496.6	3	146,269.2	1	10,475.9	1	457,751.5		